



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/501

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 32 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдад малчдын зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 11,460,000 (арван нэгэн сая дөрвөн зуун жаран мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2013 оны 10 сарын 07 ны  
өдрийн 30 дугаар захирамжийн хавсралт



**ШААРДАГДАХ ЗАРДАЛ**

№	Зардлын нэр	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Амтат алим	6,000	1,500кг	9,000,000
2	Сав, баглаа, боодол, шошго			2,460,000
	<b>Нийт дүн</b>			<b>11 460 000</b>

\_\_\_ооо\_\_\_

